



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны 11 дүгээр сарын 13-ны
өдөр

Улаанбаатар хот

Дугаар А-429/257

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллагуудад мэдэгдэн, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/-д, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-д тус тус үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН,

САНГИЙН САЙД

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Н.ЦЭРЭНБАТ

Х.ХҮРЭЛБААТАР

Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд,Сангийн сайдын хамтарсан

2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар тушаалын хавсралт

Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт

Дараах үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна.Үүнд:

1.Хуванцар сав суулга, түүхий эд;

2.Нийлэг уут түүний түүхий эд;

- 3.Бүх төрлийн зай хураагуур, аккумулятор;
- 4.Хими цэвэрлэгээний бодис;
- 5.Шилэн лонх сав;
- 6.Өндөр даралтат сав;
- 7.Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол;
- 8.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн сэлбэг хэрэгсэл, дугуй;
- 9.Бүх төрлийн машин механизмын тос, тосолгооний бүтээгдэхүүн;
- 10.Мөнгөн ус агуулсан бараа бүтээгдэхүүн;
- 11.Аюултай хог хаягдал.